

МҮХАҮТ-ын Даргын 2020 оны 07 сарын 31-ны
өдрийн 164 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хөгжлийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулан, хувийн хэвшил, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, ногоон эдийн засаг, компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэн хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж буй дотоод гадаадын байгууллага, компани, аж ахуйн нэгж, хувь хүнийг МҮХАҮТ-ын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, тодорхойлох, материалыг хүлээн авч судлах, шийдвэрлэх, гардуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 МҮХАҮТ-ын шагналыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч болон Даргын шийдвэрээр олгоно.

Хоёр. Шагнал олгох болзол

- 2.1 МҮХАҮТ-ын дээд шагнал “ХИЙМОРЬ” хүндэтгэлийн одонгоор Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшил, Монгол Улсад хувийн хэвшил, бизнесийг хөгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж бизнесийн бүхий л салбарт өндөр үр ашигтай дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн олон жил тогтвортой ажиллаж онцгой үр дүнд хүрсэн компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, мөн хувийн хэвшлийн хөгжлийг дэмжин ажилладаг төрийн болон олон нийтийн байгууллагын ажилтан, хувь хүнийг шагнана. Шагналд нэр дэвшигч тухайн салбартаа 10-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх шаардлагатай. Одонг 300.000 /гурван зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.
- 2.2 МҮХАҮТ-ын шагнал “SILK ROAD” хүндэтгэлийн одонгоор Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийн хөгжлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй гадаадын иргэд, гадаадын хөрөнгө оруулалттай компани, аж ахуйн нэгжийг шагнана.
- 2.3 МҮХАҮТ-ын “БИЗНЕСИЙН ЭРХЭМСЭГ ОРШИХУЙ” /“BUSINESS EXCELLENCE AWARD”/-н шагналаар Монгол Улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийг хөгжүүлэхэд олон жил бодитой хувь нэмэр оруулан амжилттай ажиллаж буй дотоод, гадаадын аж ахуйн нэгж, компанийг шагнана.
- 2.4 МҮХАҮТ-ын “ENTREPRENEURSHIP SPIRIT” хүндэт тэмдэгээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийн

хөгжлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй монголын бизнес эрхлэгчид болон гадаадын иргэдийг шагнана. Нэр дэвшигч тухайн салбарт 8-аас доошгүй жил ажилласан байна. Хүндэт тэмдэгийг 100.000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.5 МҮХАҮТ-ын **“GREENPRENEUR”** хүндэт тэмдэгээр Монгол Улсад ногоон бизнес, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй монголын бизнес эрхлэгчид болон гадаадын иргэдийг шагнана. Нэр дэвшигч тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан байна. Хүндэт тэмдэгийг 100.000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.6 МҮХАҮТ-ын **Шилдэг залуу бизнесмен** тэмдэгээр Бизнесийн салбарт өөрийн бодит хувь нэмэр, санал санаачилга, бүтээмжийг бий болгон амжилттай ажиллаж буй залуу бизнес эрхлэгчдийг шагнана. Нэр дэвшигч тухайн салбарт 6–аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байна. Шилдэг залуу бизнесмен тэмдэгийг 100.000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.7 МҮХАҮТ-ын **Хүндэт Жуух** бичгээр худалдаа, үйлдвэрлэл, бизнесийн чиглэлээр тухайн салбарт 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан хувийн хэвшлийн болон бизнесийн орчинг дэмжин ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнуудыг шагнана. Хүндэт Жуух бичгийг 80.000 /наян мянга/ төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.8 МҮХАҮТ-ын **Хүндэт Өргөмжлөл-өөр** худалдаа, үйлдвэрлэл, бизнесийн чиглэлээр 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан хувийн хэвшлийн болон бизнесийн орчинг дэмжин ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнуудыг шагнана. Хүндэт Өргөмжлөлийг 50.000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.1 Шагналд нэр дэвшигч нь энэхүү журмын хоёрдугаар хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан байна.

3.3 Энэхүү журмын хоёрдугаар хэсэгт заагдсан шагналууд МҮХАҮТ-ын санаачлагаар олгогдоно.

3.4 Шагналд нэр дэвшүүлэх санаачилгыг салбар танхим, зөвлөл, мэргэжлийн холбоо, нэр дэвшигчийн ажиллаж буй үндсэн байгууллага, аж ахуйн нэгж гаргах бөгөөд шагналд нэр дэвшигчийн үйл ажиллагаа болон ажлын үр дүнгийн талаар тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтод шагнуулах үндэслэл, ажлын амжилтыг үнэн зөв, тодорхой тусгаж холбогдох тооцоо судалгааг хавсаргасан байна.

- 3.5 Шагналд нэр дэвшигчийн тодорхойлолтод тодорхойлж буй байгууллагын удирдлага гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

Шагналд нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

а/ Байгууллагын албан тоот

б/ Нэр дэвшигчийн анкет /энэ журмын хавсралтаар батлагдсан анкет/

в/ Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт, байгууллага бол үйл ажиллагааны танилцуулга

г/ Хамт олны хурлын тэмдэглэл

- 3.6 Шагналд нэр дэвшигчийн материалыг гардуулахаас 14 хоногийн өмнө холбогдох газарт бүрдүүлж өгсөн байна.

Дөрөв. Шагнах асуудлыг хянан шийдвэрлэх

- 4.1 Шагнуулахаар ирүүлсэн материалыг танхимын Хүний нөөцийн газар хүлээн авч бүртгэн танхимын Дарга болон Тамгын даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 4.2 Өмнө авсан танхимын шагналаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшингээсээ ахисан тохиолдолд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ.
- 4.3 Шагнагдаж буй компани, аж ахуйн нэгж нь тухайн шагналын хураамжийг доор дурдсан үнэлгээний дагуу МҮХАҮТ-ын дансанд тушаасан байна.

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ШАГНАЛД
НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ**

1. Овог:
2. Нэр:
3. Төрсөн огноо:
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот:
.....
6. Одоогийн харъяалал:
.....
7. Нийгмийн байдал:
8. Регистрийн дугаар:
9. Боловсрол:
10. Ажилладаг салбар:
.....
11. Мэргэжил:
.....
12. Урьд ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа аж ахуйн нэгж,
байгууллага:



13.

№	Ажлын байрны нэр	хугацаа	Эрхэлсэн ажил

14. Урьд шагнагдаж байсан байдал:

№	Шагналын нэр	Шагнагдсан он

15. Шагнуулах үндэслэл:
.....
16. Ямар шагналаар шагнуулах:
17. Хамт олны хурлын саналын хувь:

Жич: Шагналын материалд анкетын хамт албан тоот, нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт, хамт олны хурлын тэмдэглэлийг хавсаргасан байна.